НАРАН СУМЫН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
НЭГДСЭН ТАЙЛАН

2023.03.24 № 03 Хонгор

**ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2022 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг суманд амжилттай зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэн хүргүүлсэн. Үүнд:
Нийт – 142779 толгой мал тоологдсоноос:
Адуу – 10561
Тэмээ – 214
Үхэр – 14301
Хонь – 76715
Ямаа – 40988

Хүн ам: Нийт – 1690, өрх – 491 тус тус тоологдсон байна.

Дарьганга сумын отрын нутагт өвөлжиж байгаа сумынхаа малчдаар 3 хоногийн хугацаатай Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг, ИТХ-ын дарга Ө.Гантулга, 1, 2-р багийн Засаг дарга С.Сугар, Ц.Төмөрсүх, ЗДТГ-ын аж ахуй нярав Ц.Батхүү нарын хамт 570км явлаа. Нийт 19 хот айлын 21,0 мянган мал өвөлжсөн ба Малчдынхаа буусан газар нутагтай танилцаж, тэдний санал бодлыг сонсож, шийдвэрлэх асуудлыг ярилцаж явсан.

Хилийн 0184-р анги, сумын засаг даргын тамгын газар хамтран 2023 оны 01 сарын 06-ны өдөр улсын хилийн зурвaст тулсан Хангилагийн пост орчмын малыг нутгийн гүн рүү татах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 2000 гаруй малыг татсан байна.

Цэргийн шинэчилсэн бүртгэл 2023 оны 01-р сарын 04-ний өдрөөс 01 сарын 20-ныг хүртэлх хугацаанд явагдаж, цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлыг амжилттай зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын дарга дүн тоо мэдээг тушаасан.

Иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, хууль зүйн чиглэлийн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг хийх, хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий эрх зүйн хөтчөөр Төрийн байгууллагын 3 албан хаагчийг томилон Аймгийн Хууль, эрх зүйн хэлтэстэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Үндсэн хуулийн өдрийн угтаж сумын эрх зүйн хөтчүүд иргэд, албан байгууллагуудын албан хаагчдад Үндсэн хуулийн талаар сургалт явуулж, АХА тэмцээн зохион байгуулсан.





Сумын засаг даргын дэргэдэх Хил Хамгаалах Туслах Хүчний Зөвлөгөөн 2023 оны 2 сарын 3- нд ЗДТГ-т зохион байгуулагдлаа.
-Зөвлөгөөнд Хилийн 0184-р ангийн удирдлагууд болон Онгон сумын отрядын дэргэдэх тагнуулын тасгийн дарга нар оролцож Хил Хамгаалах Туслах Хүчний 2023 онд хийх ажил арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.












Аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөнд ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, Санхүү албаны дарга нар оролцож, Аймгийн Засаг дарга Сумын Засаг даргатай Төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээгээ байгууллаа. Мөн Алсын хараа-2050 сургалтанд хамрагдлаа.




17-р жарны Үзэсгэлэн болгогч хэмээх харагчин усан “Туулай “ жилийн босгон дээр "Аймгийн Аварга Малчнаар" тодорсон:
2-р багийн малчин Бүлтгэрийн Энхчулуун
1-р багийн малчин Дуламрагчаагийн Батхүү
2-р багийн малчин Өлзиймэндийн Болд нарын шагналыг Аймгийн Засаг Дарга М.Идэрбат, Хурлын Төлөөлөгч Ө.Тайвансанаа, Сумын Засаг Дарга Л.Оч, ИТХ-ийн дарга Ө.Гантулга болон Багийн Засаг Дарга нар гардууллаа.








Эрдэнэт мал сүргээ өсгөн үржүүлж 2022 оны “Сумын сайн малчин “ өрхөөр
1-р багийн малчин ВЛАДИМАРЫН ЭНХБАЯР
1-р багийн малчин РЕНЧИНДОНДОВЫН НЯМСҮРЭН
2-р багийн малчин ТҮВДЭНГИЙН ЦОГ
2-р багийн малчин ЛХАСҮРЭНГИЙН ДАВАА
3-р багийн малчин ЭРДЭНЭБААТАРЫН ТАЙВАНБААТАР нар тус тус шалгарчээ.
“СУМЫН МЯНГАТ МАЛЧИН” өрхөөр
1-р багийн малчин ЧИМЭДЦЭЕЭГИЙН ГАЛХҮҮ
2-р багийн малчин БААТАРСҮХИЙН АРИУНБОЛД
2-р багийн малчин БААТАРСҮХИЙН АРИУНБААТАР
2-р багийн малчин ӨЛЗИЙБАЯРЫН НАТАР нар тус тус шалгарч шагн лыг гардууллаа.

2 сарын 7-ны өдөр УИХ-ын гишүүн Н.Ганибал болон сумын удирдлагууд хил орчмын айл өрхөөр явж өвөлжилтийн байдалтай танилцаж, малчдаар орж санал хүсэлтийг нь сонсож ажиллалаа.






Багийн засаг дарга нар 1 сарын 07-08нд хилийн торонд уруудсан малыг торноос гаргаж нутгийн гүнрүү татах ажлыг хилийн 0184-р анги, заставуудтай хамтран зохион байгуулсан.




Малын тоо толгойн албан татвараас иргэн Т.Дэлгэрцогттой гэрээ байгуулан сумын нөөцөнд 800 шуудай хивэг хүлээн авч, 1ш хивгийг 12500 төгрөгөөр буюу хөнгөлөлттэй үнэр иргэдэд тараах ажлыг зохион байгууллаа.




Аймгийн засаг даргын 01 албан даалгавар, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 албан даалгавар, Сумын засаг даргын 01 албан даалгавар, Аймгийн мал эмнэлгийн газрын даргын 08 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор 03 дугаар сарын 09-ний өдрөөс өвөлжилтийн хүндрэлээс болж хорогдсон малын сэг зэм устгах ажлыг багийн дарга нар, байгаль хамгаалагч, нярав мөн орон нутгийн өмчит газрын ажилчид ажиллалаа. Сумын нэгдсэн хогийн цэгт хуримтлагдсан сэг зэмийг тусгайлан бэлтгэсэн нүхэнд хийж устгасан. 20-ны өдрийн байдлаар 487 бог, 49 бодын сэг зэмийг устгаад байна.








**-**Алсын хараа-2050 цахим сургалтанд Төрийн байгууллагын нийт – 6 удирдах ажилтан, 58 албан хаагч 100% хамрагдаж, үнэмлэхээ авсан.




**<u>УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧИГ:</u>**

**-1-р улирлын байдлаар** дээд газраас нийт 93 албан бичиг ирснээс, хариутай бичиг 30 ирж, 23 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 7 албан бичиг байна.

-**1-р улирлын байдлаар** нийт 14 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж –10, Аймгийн Засаг даргын Албан даалгавар-1, Аймгийн ИТХ-ын Тогтоол – 2, БОАЖЯ-ны Сайдын албан даалгавар 1 ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээллэн ажиллаж байна.

**<u>Дотоодын ажлын талаар:</u>**

2023 оны 1-р улирлын байдлаар;

1.Сумын Засаг даргын А-Захирамж - 29
2.Сумын Засаг даргын Б-Захирамж – 14
3. Албан даалгавар - 2
4.Засаг даргын албан бичиг -24
5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 4
6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 16
7.ЗДТГ-ын даргын албан бичиг -34

Нийт 31 албан бичгийг цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

**<u>Өргөдөл гомдлын талаар:</u>**

2023 оны **1-р улирлын байдлаар** иргэдээс Сумын Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнууд, албан байгууллагуудад хандаж 122 өргөдөл гомдол ирж, шийдвэрлэгдсэн 121, хугацаа болоогүй 1, шийдвэрлэлтийн хувь 99,2%-тай байна.

## САНХҮҮГИЙН АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Сумын ИТХ-н 2022 оны 12 сарын 19-ны өдрийн 3 тоот тогтоолоор сумын 2023 оны төсөв батлагдсан.

2023 оны батлагдсан төсөв болон Төсөвт байгуулагуудын төсвийн сарын хуваарийг сумын Засаг даргын захирамжаар баталж аймгийн төсөв төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн.

1 сарын 4-6нд аймгийн Санхүү төрийн хэлтэс дээр Fiscal системд 2023 оны төсвийн орлого, зарлага, сарын хуваарийг оруулж ажилласан.

2022 оны төсөвт 6 байгууллагуудын санхүүгийн тайланг 1 сарын 24-нд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

2023 оны 1 сараас төрийн сангийн гүйлгээ цахимд шилжиж finance.gov.mn хаягаар төрийн сангийн гүйлгээ гаргахад холбогдох мэдээлэл данс холбох ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Цахимаар бүх төлбөр тооцоо хийгдэж байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг төсөвт 6 байгууллагууд хуулийн хугацаанд 1 сарын 25-нд сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын байгууллагад хүргүүлэн 2 сарын 6-10-д аудит хийлгүүлж ажиллаж байна.

***Статистик:*** Мэдээ тайлан хүргүүлэх 2023 оны Сумын засаг даргын А/12 дугаар захирамжийг төлөвлөж батлуулсан.Мэдээ тайлангийн графикийн дагуу 02 дугаар сарын аж үйлдвэрийн мэдээ болон ААНэгжийн дэлгэрэнгүй, хураангүй 22 мэдээг sukhbaatar.nso.mn хаяг руу хүргүүлсэн.

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа бага, дунд ангийн хүүхдийн судалгааг ЕБСургуулийн нийгмийн ажилтантай хамтран гаргасан.

03 сарын 06 нд хамтарсан баг хуралдаж холбон зуучлагчаар ирсэн 2 албан бичгийн дагуу асуудлыг хэлэлцэж 2 гэр бүлийн гишүүдтэй уулзаж кейс нээж ажилласан.Кейсийн хариуг холбогдох байгууллагат хугацаанд нь хүргүүлсэн.








Нээсэн 2 кэйсийг НАМС-ийн программд шивэлт хийж ажилласан.

Хамтарсан баг, соёлын төв, ебс хамтран 03 сарын 06 нд “Цэцэгсийг сонсъё” охидыг уулзалтыг зохион байгуулсан.

 

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын цаг уурч, хөдөө аж ахуйн мэргэжилтэн нарын хамтаар сумын 1-р багийн нутаг Цөнгөрөг, 2-р багийн нутаг Ноён хөндий, 3-р багийн нутаг Тайгын хөндий зэрэг 3 цэгт цасны хэмжилт хийж цасны хэмжилтээр цасны зузаан 5-8 см, өвөлжилт хүндрэх төлөвтэй байгааг цаг тухайд нь мэдээллэж ажиллалаа.

 

Монгол улсын үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан иргэдэд хуулийн мэдлэг олгох, сурталчилан таниулах зорилгоор хууль эрх зүйн хөтөчийн хамтаар сумын эрүүл мэндийн төв, засаг даргын тамгын газрын албан хаагч нарт Үндсэн хуулийн талаар сургалт зохион байгуулж танин мэдэхүйн АХА тэмцээн явуулан 1, 2-р байр эзлүүлсэн. Эрүүл мэндийн төвөөс 13, ЗДТГ-аас 17, нийт-30 хүн уг сургалтанд хамрагдсан.

 



БНАТ 7, 8 мэдээг хугацаанд шивж оруулсан, мөн БОХ тайлан мэдээг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Цаг агаарын нөхцөл байдлаас үүдэн хоньтойгоо төөрөн гэрээ олохгүй байсан 1-р багийн иргэнд сумын онцгой комиссын гишүүд шуурхай хүрч ажиллаа.





Дарьгангын байгалийн цогцолборт газрын захиргааны дарга Н.Ариунцэцэг-р ахлуулсан ажлын хэсэг ирж орчны бүсийн зөвлөл байгуулах тухай мэдээ мэдээллийг өгч ажилласан.
Сумын цагдаагийн тасагт ховордсон ан амьтны судалгааг гаргаж өгсөн.

Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх тухай сумын засаг даргын 2023 оны 03 сарын 06-ны өдрийн 02 албан даалгаварыг гарган албан байгууллага, ААН, иргэдэд танилцуулан тус албан даалгаварын дагуу ажиллаж байна.

**ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

- Төрсний бүртгэл – 3
- Нас барсан – 3

Иргэний цахим үнэмлэх олголт:

- Иргэний үнэмлэх захиалга ИУБ-31 – 12 иргэн
- Иргэний үнэмлэх олголтын бүртгэлд – 9 иргэн
- Иргэний үнэмлэх лавлагаа – 16 иргэн
- Иргэний үнэмлэхийн лавлагаа олголт албан хэрэгцээнд – 3 иргэн
- Оршин суугаа хаягын лавлагаа – 3 иргэн

Иргэний шилжилт хөдөлгөөн:

- Сум хооронд шилжиж ирсэн насанд хүрсэн – 1
- Баг хооронд ирсэн насан хүрсэнд – 2, хүүхэд-1
- Тоон гарын үсэг олгосон байдал – 10 иргэн

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Сум хөгжүүлэх сангаас зээл аваад эргэн төлөх хугацаа дууссан 5 зээлдэгчийн холбогдох материалыг Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд бүрдүүлэн явууллаа.

2023 оны 1 сард Наран сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээ хангаж, хүнсэнд хэрэглэсэн малын тоо, зах зээлд борлуулсан малын тоо, сүүний нөөцийг тус тус тооцон гаргасан.

2022-2023 оны Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ,Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 06 дугаар албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан ажилласан. Аймгийн Засаг даргын 06 дугаар албан даалгаврын дагуу сумдын аюулгүйн нөөцөд өвс тэжээл бэлтгэн нийлүүлэх чиглэлийн дагуу Дарьганга сумын 1-р багийн иргэн Б.Батхүрэлтэй, Сумын засаг дарга болон ХААТ гэрээ байгуулан сумын өвсний

фондод 4000 буюу 80 тн боодол өвс татан авч иргэдэд 1ш 5000 төгрөг буюу хөнгөлөлттэй үнээр малчдад тараах ажлыг зохион байгууллаа.



Аймгийн ХААГ-аас цаг хүндэрч байгаа Баяндэлгэр, Онгон, Наран сумдад нэг ширхэгийг 5000 төгрөгөөр тооцон тус бүр 1000 боодол өвсийг олгосон бөгөөд манай сум малчдадаа олгохдоо сумаасаа тээврийн хөлсийг гарган анх авсан 5000 төгрөгөөр худалдан борлуулсан.











- Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн суурь системийг шинэчлэн 409 өрхийн мэдээллийг livestock.mofa.gov.mn сайтад Статистикийн мэдээлэлтэй тулган бүртгэлээ.




| № | Эцэг/Эхийн нэр | Нэр | Регистр | Малчны төрөл | Малчны код | Хаяг | Утас | Малын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХАЛТАН | АДЪЯА | ЛЕ85030116 | Мал бүхий өрх | 2216550003921 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 90005556 | Харах |
| 2 | НАМСРАЙ | АМАРСАНАА | ЛЕ83042811 | Малчин өрх | 2216550001121 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 91193938 | Харах |
| 3 | ГАЛСАН | АМАРТҮВШИН | ЛЖ87021014 | Малчин өрх | 2216550101222 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 90240032 | Харах |
| 4 | ЛХАМЖАВ | АРИУНБОЛД | ЛЕ83040910 | Мал бүхий өрх | 2216550100121 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 91865401 | Харах |
| 5 | ЦОГБАДРАХ | АРИУНБОЛД | ЛГ86081615 | Мал бүхий өрх | 2216552100001 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 96260880 | Харах |
| 6 | ЛХАМСҮРЭН | БААТАРСҮХ | ЛЕ59082078 | Мал бүхий өрх | 2216550006521 | Сүхбаатар, Наран,3-р баг, Наранбулаг | 96704671 | Харах |

- Статистикийн мэдээ ХАА1,ХАА2, ХАА3 мэдээг хугацаанд нь шивж Хөдөө аж ахуйн газарт 7 хоног бүрийн 3 дах өдөр төл хорогдолын мэдээг сар бүрийн 15-ны өдөр ХАА10 мэдээг шивж ажиллаж байна.

## МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

20 өрхөөс нохойн судалгааг авч ажилласан. 2 сард 8 золбин нохойг устгах ажил хийгдсэн.

Аймгийн мал эмнэлгийн газарт нохойтой өрхийн судалгааг гаргаж хүргүүлсэн.

Мал эмнэлгийн нэгдсэн системийн шинэчлэлийн цахим сургалтанд хамрагдаж мэдээлэл авсан. 2 аж ахуй нэгжийн эмч нарт мэдээллийг хүргэж сургалт өгч шинэ программыг 2023 оны 01 сары 01-ний өдрөөс эхлэн ашиглаж өдөр тутмын ажил үүргээ хэрэгжүүлж байна. Цахим гэрчилгээ олголт хэвийн явагдаж байна.

Бог малын мялзан өвчний судалгааг малтай 30-н өрхөөс авч цахимд оруулсан.

2 багийн 9 өрхөөс хээл хаялтын судалгааг авч хүргүүлсэн.

Малчдад өвөлжөө хашаа хорооны цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэлийн ач холбогдол мөн мялзан өвчний талаар гарын авлага бэлтгэн мэдээлэл хүргэж ажилласан.




## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**12 дугаар сарын 26, 1 дүгээр сарын 25-нд ejob хөдөлмөр эрхлэлтийн программын онлайн сургалтанд хамрагдсан.Ejob программд ажил хайгч 13,шинэ ажлын байр-1 иргэнийг бүртгэсэн.

ХЭДС-аас олгогдох жижиг зээлийн талаар зарыг сумын 2 группт мэдээлэл байршуулан 12 иргэнд зээлийн талаар заавар өгөн 2 иргэний төсөл явж дэмжигдсэн.

ОНОТХҮ-ий төсөлд хамрагдсан 2 иргэнд профайлинг үнэлгээ хийсэн.

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 6 иргэний 3196250 төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн.

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд төсөл хөтөлбөр болон ХЭДС зээлд хамрагдаж байгаа 2 иргэнийг оролцуулсан.

2023 онд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар сумын группэд зар хүргэн 8 иргэнд цахимаар,утсаар биеэр мэдээлэл өгсөн.

3 дугаар сарын 16-ны өдөр 2023 онд амьжиргааг дэмжихээр сонгосон 13 өрхийн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа,”Энэ жилдээ-Эрүүл жиндээ” дасгал хөдөлгөөний талаар нийтийн биеийн тамирын арга зүйч Б.Баасанжавтай хамтран  сургалт мэдээлэл хийн нийтийг хамарсан ажил мод тарих ажилд ажиллах иргэдийг бүртгэн витаминжуулсан.








3 дугаар сарын 20-ны өдөр амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар сургалт мэдээлэл хийлээ.




Нийтийг хамарсан ажлын төслийг ХХҮГ-т хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулах талаар Засаг даргын албан бичгийг хүргүүлсэн.


СҮХБААТАР АЙМГИЙН
НАРАН СУМЫН ЗАСАГ ДАРГА

22060 Хонгор Наран сум

2023.03.20 № 01/22

танай ______ -ны № ______ -т

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ө.БОРГИЛ
ТАНАА

Танай байгууллага нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 дахь заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн авч ажиллуулах ёстой боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулаагүй тул хуулийн 144.2, 144.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдэж байна.

Тухайн иргэнийг авч ажиллуулаагүй тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр (550000) сар бүр төлбөрийг төлж хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх болно.

Л.ОЧ


МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 сарын 02 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

**144 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт**

144.1.Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй.

144.2.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна.

144.3.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т заасанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө.

144.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, эсхүл хөнгөлж болно.

144.5.Энэ хуулийн 144.3-т заасан төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална. Энэ төлбөрийг гагцхүү хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зарцуулах бөгөөд төлбөр хураалт, зарцуулалт, үр ашгийн талаар жил бүр олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнана.

144.6.Ажил олгогч энэ хуулийн 144.1-д заасан тохирох хэрэглэгдэхүүнээр хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглоно.

Мэргэжлийн сургалтын зарыг тавин 6 иргэнээс захиалга аваад байна.

**Нийгмийн халамжийн чиглэлээр**:Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 4 удаа хийж асаргаа сунгуулах 6 иргэн, асран хамгаалагч солих 1,сар шинийн баяраар байгууллагын харъяалалгүй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ахмадын нэрсийг хэлэлцэх,2023 онд амьжиргааг дэмжих 13 өрх сонгох,ОНОТХҮ-ий бүлгийн төслийг хэлэлцсэн.

Хүүхдийн мөнгө нь орохгүй байгаа иргэдэд заавар чиглэл өгч ажиллах ажлын хэсгийг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/16 тоот захирамжаар байгуулсан.

Хүүхдийн мөнгө шинэ журмаар олгох болсонтой холбогдуулан 1 дүгээр сарын 16-нд онлайн сургалтанд,18-нд онлайн хуралд хамрагдаж заавар чиглэлийн дагуу 65 иргэнд хүүхдийн мөнгөний мэдээллийг шалгаж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

1 дүгээр сарын 18-нд ЭМТ,ЗДТГ-ны 29 ажилтанд хүүхдийн мөнгөний талаар мэдээлэл хийсэн.






Сонгогдсон зорилтот өрхийн хөдөлмөрийн насны 5 иргэнд ОНОТХҮ-ий төслийн талаар танилцуулан бүлэг болж төсөл хэрэгжүүлэх иргэдэд заавар чиглэл өгч ажиллаж материалыг бүрдүүлэн хугацаанд нь хүргүүлсэн.

3 дугаар сарын 20-нд сургуулийн нийгмийн ажилтан,эмчтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдээр явж нийгмийн халамжийн гарын авлага,хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжих үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөн гарын бэлгийг гардуулсан.







**Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 3 дугаар сарын 20-ны байдлаар**

| № | Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл | Хүний тоо | Мөнгөн дүн /мян.төг/ |
|---|---|---|---|
| 1 | Нийгмийн халамжийн тэтгэвэр | 89 | 4700000 |
| 2 | Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг | 99 | 9007799 |
| 3 | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд | 47 | 8322720 |
| 4 | Ахмад настны тухай хуулийн дагуу | 80 | 6620000 |
| 5 | ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу | 33 | 640645 |
| 6 | Жирэмсэн эхийн тэтгэмж | 41 | 1475714 |
| 7 | Алдарт эхийн одонтой эхэд | 139 | 10540000 |
| 8 | Хүүхэд асарсны тэтгэмжинд | 275 | 13312499 |

**ТАТВАРЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Татварын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.Татвар төлөгчид татварын холбогдолтой цахим сургалт болон зөвөлгөөг сумын групд шэйр хийж 107 хүн мэдээлэл авсан. Мөн өөрийн хариуцсан ААН-ээр явж онцгой албан татварын лац болон төлбөрийн баримт олголтын талаар хяналт тавьсан.

2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 2022 оны жилийн эцсийн хувь хүний орлогын албан татварын тайлан хүлээн авах, хөнгөлөлт, чөлөөлт, буцаан олголтын талаар Эрүүл мэндийн төвийн 14 албан хаагчдад, Засаг даргын тамгын газрийн 15 албан хаагчдад, ХААН

банкны 4 ажилтан нийт 33 хүнд etax.mta.mn системд хэрхэн бүртгүүлэх, тайланг хэрхэн үнэн зөв илгээх хөнгөлөлт чөлөөлтөнд хэрхэн хамрагдах талаар  сургалт зөвөлгөө өгсөн.   Сургалтанд оролцогчидоос шинэ байшин барьсан-2 иргэн, оюутны  сургалтын төлбөрийн хөнгөлт-1 хамрагдаар болсон.Хувь хүний орлогын татварын тайланг хэрхэн илгээх талаар цахим сургалтыг сумын зарын групп болон байгууллагуудын группт байршуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна. Мөн сургалтанд хамрагдсан иргэдэд цахим хичээлийг илгээсэн.





Хөнгөлөлтийн тайлангийн нэгтгэл мэдээг харъяалагдах татварын хэлтэст илгээсэн.

Сургалтын төлбөрийн буцаалт 2иргэн-396000төгрөг

Орон сууц байшингын буцаалт 6иргэн- 6167067,01төгрөг нийт 8 иргэн-6563067,01 төгрөгний хөнгөлөлт эдлэхээр тайлангаа илгээсэн ба тайланг хянаж үзэн хүлээн авсан.

Мөн 2022 оны жилийн тайлангын хугацаа 2сарын 15нд дуусаж байгаатай холбоотойгоор ААН тайлангууд болон ХХОАТ тайлан 153 хүний тайланг  хүлээн авсан.

2сарын байдлаар сумын орлогын төлөвлөгөө 40937900төгрөг байхаас 26580175,28төгрөг буюу 64,92%-тай явагдаж байна татварын орлогыг 3 сард 100% биелүүлэхээр ажиллаж байна.

2023 оны 3сарын 13наас 03сарын 17ны өдрүүдэд татварын урьд оны өрийг төлүүлэх талаар түлхүү анхаарч ажилласан болно. Үүнд:

1. ААНОАТ-13020төг
2. Газрын төлбөрт-12642төг
3. МТТАТ-513900төг
4. Суутган-4-257550төг
5. ХХОАТ-109220,22төгрөг зэрэг урьд оны 906332,22төгрөгийг аймаг сумын төсөвт төвлөрүүлж ажилласан.

**ГАЗРЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Тухайн оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэд,ААН байгууллагаас саналыг хүлээн авч боловсруулан Газар зохион байгуулалтын системд оруулж ИТХ-ын 2022 оны 12 сарын 19 ны өдрийн 02 тоот тогтоолоор ГЗБТөлөвлөгөөг батлуулан

➤ Төсөвт байгууллагын байнгын хэрэгцээнд эзэмшүүлэх -6 нэгж талбар

➤ Гэр бүлийн хэрэгцээнд шинээр эзэмшүүлэх -2 нэгж талбар нийт 8 нэгж талбарын өргөдлийг хүлээн авч засаг даргын шийдвэрийг гаргуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Мөн шинээр эзэмших өргөдлийг хүлээн авч бүртгэн Улсын бүртгэл рүү "Э" дугаарыг захиалан цахим гэрээ ,гэрчилгээг үүсгэн нэгж талбарын хувийн хэргийг бүрдүүлэн хавсаргаад байна .

Агентлагийн Кадастрын хэлтсийн мэргэжилтэнтэй холбогдон 02216-05-00149-11 өргөдлийн хуулийн этгээд буруу бүртгэгдсэн байсныг засуулж гэрээ цуцалсан төлөвтэй байсныг хүчинтэй болгон засуулсан.

02216-01-00225-12 үнэгүй өмчилсөн өргөдөл бүртгэсэн болон буруу регистрээр давхар өмчлөл үүсгэсэн байсныг зөв регистрийн дугаарыг өгч засварлуулсан.

Газрын төлбөр ногдуулахад алдаатай засварлах шаардлагатай байсан 02216-05-00178-13 өргөдлийн хуулийн этгээдийн регистрийн дугаарыг засварлуулсан.

Сумын засаг даргын 2023 оны 01 сарын 30ны өдрийн А/08 тоот захирамжаар газар эзэмших ашиглах эрхийн нээлттэй цахим дуудлага худалдааг 4н байршилд 2023 оны 03 сарын 6 ны өдөр зохион байгуулахаар зарыг mle.mn-газрын бирж болон аймаг сумын facebook групп дээр байршуулан хугацаанд нь дуудлага худалдааг зохион явуулж 3н газрын ялагч нартай гэрээг байгуулан дуудлага худалдааны орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.







| № | Газрын байршил | Нэгж талбарын дугаар | Газрын хэмжээ /га/ | Газрын зориулалт | Анхны үнэ | Дэнчингийн хэмжээ | Дуудлага худалдаа явуулах хэлбэр | Зохион байгуулагдах он сар, өдөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Наран сум 3-р баг Ширээт | 3113542 | 0.3482 | Төмс хүнсний ногооны усалгаатай тариалан | 43.246 | 4324.6 | Цахим | 2023-03-06 |
| 2 | Наран сум 3-р баг / Өвөрхий фондны урд талд / | 3041060 | 0.3 | Үйлдвэрлэлийн барилга байгууламж бусад газар | 1.960.000 | 196000 | Цахим | 2023-03-06 |
| 3 | Наран сум 2-р баг / Хар нуур/ | 3088286 | 0.04 | Холбоо, мэдээлэл хүлээн авах станц | 320.000 | 32000 | Цахим | 2023-03-06 |
| 4 | Наран сум 1-р баг /Мулуун хороот/ | 3088285 | 0.04 | Холбоо, мэдээлэл хүлээн авах станц | 320.000 | 32000 | Цахим | 2023-03-06 |

Дуудлага худалдаагаар шинээр эзэмших 3н нэгж талбарын өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.

- Холбоо мэдээлэл хүлээн авах станц -2 нэгж талбар
- Төмс хүнсний ногооны усалгаатай тариалан-1 нэгж талбар

Газрын даргын 2023 оны 01/34 тоот албан бичгийн дагуу газрын татвар, төлбөрийн ногдуулалтыг иргэд ,аж ахйн нэгж бүрээр шалган нэхэмжлэхүүдийг үүсгэсэн.Газрын төлбөрийн ногдуулалтыг 46 иргэнд үүсгэсэн.

Газрын татварын ногдуулалтыг 231 иргэнд үүсгэж алдаатай байсан нэг иргэний регистрийн дугаарыг засварласан.

2023 онд төлбөрийн тооцоо нийлсэн актыг 1 иргэнд хэвлэн өгсөн .



ГХБХБГаас " Газрын нэгдсэн төлөвлөлт хийх " аймаг , сумын салбар дундын олон талт ажлын хэсгийг чадавхижуулах сургалт хэлэлцүүлэгт 2023 оны 03 сарын 14-16 ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд цахим хэлбэрээр хамрагдлаа. Үүнд:

- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний явц,анхаарах асуудлууд
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглах арга замуудыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах нь
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох , бууруулах арга хэмжээнүүдийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах нь











2023 оны 03 сарын 17 нд ГХБХБГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах болон бусад сургалтуудад хамрагдлаа.Үүнд:

- Бүтээмж ,санаачилга
- Иргэний болон эрүүгийн хуулийн мэдээлэл
- Захиргааны ерөнхий хуулийн талаарх мэдээлэл
- Өсөх сэтгэлгээ
- " Төрийн албан хаагч, Төрийн албан хаагчийн ёс зүй"

- Геодезийн байнгийн цэг тэмдэгтийг геопортал цахим системд бүртгэх мэдээлэл
- 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ болон 2023 онд Газрын чиглэлээр анхаарах асуудлууд






**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

4 ажил олгочийн 102237,6 мянган төгрөгийн шимтгэл оруулсан байна. 1447,0 сайн дурын даатгалд 22 иргэн хамрагдаж 1447,0 мянган төгрөг оруулсан. эрүүл мэндийн даатгалд 7 иргэний 472,8 мянган төгрөг оруулсан.
2 сарын 1 нд нийгмийн даатгалын хэлтэсээс 134000,0 сая төгрөгийн санхүүжилт тэтгэврийн санд авсан байна.
2 сард нийт 276 иргэнд 138618,6 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. 2 иргэнд тэтгэвэр шинээр тогтоосон.
Тэтгэмжийн даатгалын санд 6000,0 сая төгрөгийн санхүүжилт авсан. 1 иргэнд оршуулгын тэтгэмж 2000,0 сая төгрөг олгосон байна. 2 иргэнд 3082,2 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон.2 сард зөвлөлийн хурал нэг удаа хийсэн.

**БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

1-р улирлын дүн мэдээ гаргах,  анги сургалт, мэргэжил сургалтуудаа БСМС-д шивэлт  хийж сургалтын менежер батлуулах ажлыг зохион байгууллаа. Мөн 2-р улиралын төлөвлөгөө, хөтөлбөрүүдээ хийж, ажлын байран дээр дараах сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

Суралцагчдын англи хэлний ярианы чадварыг эрчимтэй сайжруулах, хөгжүүлэх ажлын хүрээнд Гүрэн академиас зохион байгуулж буй  “Astrid” ярианы чадварын аппликейшнд сурагчдыг АУБ нар болон англи хэлний багш нар эцэг эх, асран хамгаалагч нар луу нь цахимаар урилга илгээж бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сургуулийн хэмжээнд 82 суралцагч бүртгүүлээд сургалтандаа хамрагдаж байна.

Улсын хэмжээнд хэрэгжиж буй  “Сургууль хоорондын хамтын  ажиллагаа” төсөлд амжилттай хамрагдаж  “Малчны хотонд” контент бэлтгэх, боловсруулах төслийн үйл ажиллагааг багш нар 2-3 өдрийн турш амжилттай хэлэлцэж 3.7-ны өдөр сургуулийн удирдлагууд цахимаар амжилттай хэлэлцүүллээ.

Итали улсад төвтэй ASIA ТББ-аас хэрэгжүүлж байгаа “ОРОН НУТГААС ДЭЛХИЙ РҮҮ” төслийн хэрэгжилтийн явцын нээлттэй өдөрлөгийг багш, суралцагчид, эцэг эхчүүдийг хамруулан амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр:

- ✓ "Coding study club" клубын суралцагчдын танилцуулга, бүтээлийн үзэсгэлэн
- ✓ Ухаалаг дэлгэцийг сургалтад ашиглаж, сурагчдыг хөгжүүлж буй байдал
- ✓ Hours of code -сургалт, тэмцээн зэрэг үйл ажиллагааг төлөвлөн зохион байгууллаа.








Улсын төрөлжсөн олимпиадын 1-н давааг сургууль дээрээ удирдамжийн дагуу амжилттай зохион байгуулж аваргуудаа шалгаруууллаа. Үүнд: Бага дунд 15 багш мэргэжил тус бүрээр, 9-р ангийн суралцагчдын дунд 5 төрлийн хичээлээр зохион байгуулахад нийт давхардсан тоогоор 25 суралцагч амжилттай оролцож дараагийн 2-р шатанд оролцох эрхээ олж авлаа.

2023.03.18-19-ны өдрүүдэд СБ аймагт улсын төрөлсөн олимпиадын 2-н даваа амжилттай зохион байгуулагдаж 4 сурагч 10 багшийн хамт оролцож түүхийн хичээлийн төрөлд багш Э.Оюунтунгалаг 3-р байр, багын математикийн төрөлд сургалтын менежер тэргүүн байр эзэллээ.

*Сүхбаатар аймгийн Наран сумын ЕБС-н 2022-2023 оны хичээлийн жилийн*
*Улсын төрөлжсөн олимпиадын 1-н давааны дүн мэдээ*

| № | Төрөл | Сурагчийн нэр | Эзлэх байр |
|---|---|---|---|
| 1 | Англи хэл | Ч.Нандин-Эрдэнэ | I байр |
| 2 | | Э.Номин | |
| 3 | | Б.Энхжин | |
| 4 | | А.Түвшинбаяр | |
| 1 | Физик | З.Хишигжаргал | I байр |
| 2 | | Г.Зулцэцэцэг | |
| 3 | | Г.Мөнхжин | |
| 4 | | С.Ууганцэцэг | |
| 1 | Түүх | С.Хишигжаргал | I байр |
| 2 | | Г.Мягмарсүрэн | II байр |
| 3 | | Г.Зулцэцэцэг | |
| 4 | | С.Даваамягмар | |
| 1 | Биологи | А.Ариунзаяа | |
| 2 | | Г.Мөнхтуул | |
| 3 | | М.Энхсайхан | |
| 4 | | С.Даваамягмар | |
| 5 | | С.Номинцэцэг | |
| 6 | | М.Хүслэн | |
| 7 | | С.Ууганцэцэг | |
| 8 | | Б.Энхжин | I байр |
| 9 | | Б.Халиунаа | II байр |
| 1 | Орос хэл | Ч.Нандин-Эрдэнэ | I байр |
| 2 | | Г.Мөнхжин | II байр |
| 3 | | Э.Номин | |
| 4 | | А.Түвшинбаяр | |

**Зохион байгуулсан:** Улсын төрөлжсөн олимпиадын зохион байгуулах комисс





Сургуулийн захиргаанаас 2023.03.13-20-ны хооронд БДЗАН-ийн ахлагч нартай хамтран бага ангиас монгол хэл, математикийн хичээлээр, дунд ангиас судлагдахуун тус бүрээр түвшин тогтоох шалгалтуудыг авч анализ дүгнэлтийг нэгтгэн хийж ажиллаж байна.

**<u>Ажлын байрны сургалтууд:</u>**

Төрийн албан хаагчийн ERP сургалтад 2023.01.09-ны өдрийн 14 цагаас хариуцсан албан хаагч, Б.Адъяа, нийгмийн ажилтаны хамт оролцлоо.




Мэргэжлийн багш нар Aplus.MN-ийн 3 дахь удаагийн сургалтуудадаа хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж ажиллаж байна.

"Орон нутгаас Дэлхий рүү" төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад хамрагдаж, сургууль “Ухаалаг дэлгэц”ээ хүлээн авч, багш ажилтан нарт сургалтыг багш Л.Чинзориг зохион байгууллаа. Мөн ангийн ухаалаг дэлгэцийг хамгаалах самбарыг ажилчид байршуулж ажилласан.





Цэцэрлэг, сургуулийн багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, ёс зүйн зөвлөлийн ажиллах журам шинэчлэн батлагдаж, сургуулийн захиргаа ёс зүйн зөвлөлтэй хамтран багш, ажилтан нарт сургалт мэдээлэл, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан.




2023.02.13-ны өдөр "Сургууль хоорондын хамтын ажиллагаа, сургуульд суурилсан менежментийн төслийн танилцуулга" багш суралцагч - солилцоо хөтөлбөрийн цахим уулзалт хэлэлцүүлэгт удирдлагууд хамрагдаж, цаашид хийх ажлын талаар ярилцаж чиглэл авч ажилласан.




2023.02.14-ны өдөр монгол хэлний сурах бичиг, зөвлөмж, гарын авлагын зохиогч БЕГ- ын арга зүйч П. Одсүрэн багшийн цахим уулзалт, хэлэлцүүлэгт бага ангийн 5 багш,

сургалтын менежер нар хамрагдлаа. Хэлэлцүүлэгээр бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг зөв хэрэглэх, даалгавар боловсруулах арга зүй, эхийг зөв унших, бичих арга аргачлалын талаарх зөвлөгөө зөвлөмжийг өглөө.

Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Насан туршийн боловсрол төвийн захирал, сургуулийн үнэлгээ хариуцсан менежер, цэцэрлэгийн эрхлэгч нарт зориулсан "Сургалтын байгууллагын менежментийг сайжруулах нь" сургалт хэлэлцүүлэг, боловсролын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, “Алсын хараа 2050” сургалтуудад сургуулийн захирал оролцож, ажлын байранд дээр сургалтаа багш нартаа зохион байгууллаа.

Удирдлагын академиас зохион байгуулж буй сургалтын байгууллагын менежментийг сайжруулах, хувь хүний хөгжлийг дэмжих “Алсын хараа -2050” 40 цагийн цахим сургалтанд ажлын байран дээр нийт 22 багш, ажилтан хамрагдаж амжилттай төгслөө.

**<u>Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан сургалтууд:</u>**

- ✓ 12-р сарын 19-22 ны өдрүүдэд СБ аймагт зохион байгуулж буй орос хэлний ярих чадварыг хөгжүүлэх сургалтад багш Л.Болормаа хамрагдлаа.
- ✓ 2022.12.22-23 ны өдөр “Залуу багшийг чадавхжуулах” сургалтад НТНБ, Физикийн багш нар хамрагдаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж ажилласан.
- ✓ 12-р сарын 20-25-ны өдрүүдэд "Орон нутгаас Дэлхий рүү" төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад хамрагдаж, сургууль бүрийн Мэдээллийн технологи хариуцан ажиллаж буй багшид сургалтад ашиглах таблет бэлэглэлээ.



Боловсрол, шинжлэх ухааны газрын тоон болон чанарын үнэлгээгээр нийт 16 -н ЕБС-иас 6-р байр, 9-н жилийн сургуулиас 2-р байрыг эзэлсэн амжилт гаргаж 80.5%-тай үнэлэгдсэн байна. 2023.02.10








2. **<u>ХҮҮХЭД ХӨГЖИЛ- ХАМГААЛАЛ:</u>**

Суралцагчдын сонирхолыг дэмжих, хөгжил оролцоог нэмэгдүүлэх, бие даан суралцах арга барилыг хөгжүүлэх зорилгоор 6-9-р ангийн суралцагчдаас 2023 онд хичээллэх дугуйлангийн санал асуулгыг авч нэгтгэн сургуулийн захиргаанд танилцуулсан. Суралцагчид дараах дугуйланд хамрагдахыг санал болголоо. ҮҮнд:

- Гар бөмбөг, Сагсан бөмбөг, Гадаад хэл, Монгол бүжиг
- Шагайн харваа, Уран зураг, Үндэсний бичиг, Англи хэл, Илтгэх урлаг

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сарын аяны хүрээнд СӨУЗ болон бадмаараг охидын клубын суралцагчид ЭМТ-тэй хамтран төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх цахим уриалга, зөвлөмжийг эцэг эх, асран хамгаалагч нартаа хүргэж ажилласан.
- Бага дунд ангиудад хуваарийн дагуу эмч, НА-тан нартай хамтран мэдээлэл сургалтыг хийж ажилласан.
-

  

Суралцагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хуваарийн дагуу эмч үзлэг хийж, өдөр бүр томуу томуу төст өвчлөлийн талаарх мэдээлэл, зөвлөмжийг суралцагчдад болон эцэг эхчүүдэд өгч ажилласан.

**Урьдчилан сэргийлэх үзлэгийн мэдээ**

2023.02.16

| № | Анги | Хамрагдвал зохих нийт хүүхэд | Хамрагдсан нийт хүүхэд | Хувь | Ковидын өвчлөл | өвчтэй | Чөлөөтэй | Хүүхдийн өвчлөлийн байдал /тоо/ | | | | | | | Вакцинд хамрагдалт /Сахуу | | 12 настан | | 17 настан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Томуу, томуу төст өвчлөл | Шүд | Нүд | Бусад өвчлөл\дотор, арьс харшил\ | чих хамар Хоолой | Харшил | Нийт | 7 настан | 15 настан | 1-р тун | 2-р тун | 1-р тун | 2-р тун |
| 1 | 1а | 36 | 35 | 97% | | 1% | | | 28 | 1 | | 5 | | 34 | | | | | | |
| 2 | 2а | 38 | 37 | 97% | | | 1% | | 33 | 4 | | 12 | | 49 | | | | | | |
| 3 | 3а | 21 | 20 | 95% | | | 1% | | 16 | 7 | | 1 | | 24 | | | | | | |
| 4 | 3б | 23 | 23 | 100% | | | | | 16 | 2 | 1 | 5 | | 24 | | | | | | |
| 5 | 4а | 25 | 25 | 100% | | | | 2 | 19 | 3 | | 1 | | 25 | | | | | | |
| 6 | 5а | 36 | 35 | 97% | | | 1% | | 29 | 1 | | 9 | | 39 | | | | | | |
| 7 | 6а | 31 | 27 | 87% | | 2% | 2% | | 20 | 7 | 1 | 7 | | 35 | | | | | | |
| 8 | 7а | 27 | 27 | 100% | | | | | 22 | 5 | | 5 | | 32 | | | | | | |
| 9 | 8а | 22 | 22 | 100% | | | | | 20 | 3 | | 4 | | 27 | | | | | | |
| 10 | 9а | 22 | 20 | 90% | | 1% | 1% | | 16 | 4 | | 4 | | 24 | | | | | | |
| **Нийт** | | **281** | **271** | **98%** | | **4%** | **6%** | | **219** | **30** | **2** | **53** | | **304** | | | | | | |

Мэдээг гаргасан: ЕБС-н эмч С.Ууганцэцэг
Хянасан: Нийгмийн ажилтан ............................Д.Ариун-Эрдэнэ

Сургуулийн эмч урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнд суралцагчдын БЖИ-г тодорхойлж судалгаа гаргалаа. Нийт 281 суралцагч хамрагдахаас 272 сурагч хамрагдсанаас:

- ✓ Хэвийн жинтэй-190 суралцагч 67,6%
- ✓ Илүүдэл жинтэй- 78 суралцагч 27,7%
- ✓ Тарган-2 суралцагч 0,7%
- ✓ Туранхай-2 суралцагч 0,7% байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа, мэргэжил сонголтын "Алхам алхамаар" аяны хүрээнд 8,9-р ангийн анги удирдсан багш нар НТНБ-тай хамтран мэргэжил сонгоход туслах мэдээлэл зөвлөмжийг өгч ажилласан.

 


Сургуулийн захиргаанаас зохион байгуулж буй "Ном унших 1 сарын аян"-ыг цагийн хуваарийн дагуу дотуур байрны суралцагчид болон анги хамт олны дунд ажиллаж байна.





2023.03.02-ны өдөр СНА-тан сургуулийн эмч, дотуур байрны багш нар хамтран дотуур байрны сурагчдын өмнө тулгамдаж буй асуудал, дотуур байранд ажиллаж буй үйлчлэгч, тогооч, манаач нарын үйл ажиллагааг үнэлэх зорилгоор 19-20 цагийн хооронд Охид хөвгүүдэд дотно яриа өрнүүлж мэдээлэл хийж, тэдний санал бодлыг сонсож сургуулийн захиргаанд уламжилж ажилласан.





Олон улсын эх үрсийн баярын өдрийг угтан өсвөр насны охидын өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, амьдралын үнэ цэнийг ойлгуулах, зөв хүн болон төлөвшихөд нь туслах, хувь хүний хөгжлийн цогц сургалт мэдээлэлээр боловсрол олгох зорилгоор **“ЦЭЦЭГСИЙГ СОНСЪЁ”** уулзалт ярилцлагыг удирдамжийн дагуу сумын хамтарсан баг, сургуулийн захиргаа, соёлын төв хамтран зохион байгууллаа. Үйл ажиллагаанд урилгаар:

- ✓ Төрийн албанд тасралтгүй 30 гаруй жил хөдөлмөрлөсөн М.Отгон
- ✓ 2-р багийн малчин эмэгтэй Д.Ганцэцэг
- ✓ СӨБ-ын эрхлэгч, Хүүхдийн элч Ж.Хүрэлчимэг
- ✓ Эмэгтэйчүүдийн холбооны дарга О.Ганчимэг нар оролцож "Амьдралын үнэ цэнэ" сэдэвт уулзалт ярилцлагыг охидын хамт өрнүүллээ.
- Сургуулийн эмч С.Ууганцэцэг "Охидын эрүүл мэнд" сэдвээр мэдээлэл хийж охидтой дотно яриа өрнүүлэн ажилласан.
- Соёлын төвийн хамт олон охидын дунд хөгжөөнт үйл ажиллагаа - урлагийн номёр бэлтгэн явууллаа.
- Сургуулийн тогооч нар амтат цагаар цайны цагыг зохион байгууллаа.

Үйл ажиллагааг зохион байгуулахад хамтарсан багийн төсвөөс нийт 350.000 төг, сургуулийн захиргаа 50.000 төг гаргаж хамтран ажилласан.








2022.03.17-ны өдөр Эр цэргийн баярыг угтан хөвгүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортод дур сонирхолтой болгох зорилгоор 5-9-р ангийн нийт 62 хөвгүүдийн дунд "Бид спортлог хөвгүүд" сэдвийн хүрээнд “Хөгжилтэй буухиа”, “Сагсан бөмбөг”-ийн уралдаан тэмцээнийг сумын хамтарсан багтай хамтран амжилттай зохион байгууллаа. Зарцуулсан төсөв 50.0000 төг









2023.03.10-16-ны хооронд Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд болон гэр бүлийн хүчирхийлэлтэй байгаа 2 өрх гэрээр явж, тухайн нөхцөл байдалтай танилцаж кейс үйлчилгээг сумын хамтарсан багаар нээж ажиллалаа.





СБ-аймгийн нийтийн номын сангаас уламжлал болгон зохион байгуулдаг “Судар эгшиглэн-2023” төсөлд нийт сургуулийн хэмжээнд 31 сурагч бүртгүүлж амжилттай оролцож эхлээд байна.





## 3.Бусад үйл ажиллагаа:

- ✓ ЗГ-ын 482, 491 -р тушаалуудын дагуу багш, ажилчдын цалинг шинэчлэн тогтоож, БС-ын Хүний нөөцийн системд шивэлт хийх ажлыг зохион байгууллаа.
- ✓ Багш, ажилтан, суралцагчдынхаа эрүүл аюулгүй байдал, суралцагчдын эрүүл ахуй, хоол хүнсэнд хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд 2023 оны 01-р сарын 01-ны өдрөөс эхлэн сургууль дээрээ их эмч авч ажиллуулж байна.

- ✓ Дотуур байрны суралцагчдын хоол хүнсэнд зориулж нийт 10 сая төгрөгний тоног төхөөрөмж ирсэнийг байгууллагын эд аж ахуйн бүртгэлд бүртгэж дотуур байрны гал тогоог тохижуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- ✓ Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд Соёлын танхим байгуулахад нийт 1.800.000 төгрөгний аяны гэрийг сургуульдаа авчрах ажлыг С\М зохион байгууллаа.




- Байгууллагын дотоод орчин нөхцөлийг сайжруулах, ХШҮ-ний ажлын гүйцэтгэл үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор нийт 198.000 төгрөгөөр байгууллагынхаа 6-н ажлын хэсгийн самбаруудыг шинэчилж ажилласан.
-






- Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн дэг соёлыг түгээж ажиллах нийт 6 ш самбар, оролцооны байгууллагын 2 ш самбарыг хийж сургуулийнхаа тохижилтонд анхаарч ажилласан.







Сургуулийнхаа ахмад багш ажилчдад сар шинийн баярыг угтан гарын бэлэг гардуулах ажлыг зохион байгуулсан. Нийт 22 ахмадад 200.0 төг зарцуулсан болно.

Сургуулийн захиргаанаас 2023 оны хагас жилд хийх “Хяналт шинжилгээ үнэлгээ” хийх удирдамжийг боловсруулан холбогдох албан хаагчдад танилцуулж 2023.05.11-ны өдөр хэлэлцэхээр болсон.

Монголын уламжлалт сар шинийн баяр, өв уламжлал, ёс заншил, мартагдсан нэршлийг сэргээн сануулах, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор залуу багш нарын клубээс багш ажилчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

  

**1.Сургалтын чиглэлээр хийсэн ажил:**

Нийт багш ажилчдын жилиийн ажлын төлөвлөгөө болон бүлгэм бүрийн төлөвлөгөөг чиг үүргийн дагуу боловсруулан батлав.

Жилийн эцсээр нэмэгдэж ирсэн шинэ хөрөнгийг нэг бүрчлэн данс бүртгэлд бүргэн хариуцуулан ажиллаа.

Архив бичиг хэргийн баримт бичгийг ажлын хэсэг гарган бичиг баримтыг үдэж он оноор нь ангилан үдэж янзлав.

Хичээлийн жилийн нийт -16 багш ажилчид 111-хүүхдэд -16төрлийн дугуйлан хичээллэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Улаан загалмай байгууллагтай хамтран 4-багш, 4-туслах багш “нарт хувь хүний хөгжил” сургалтыг авчлаа.

Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлж буй түүхий эд бүтээгдэхүүнийг гэрээт ААН байгууллагаас татан авалт хийхэд нь хяналт тавьж хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг буцаан олголт хийж хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Багш ажилчдын хөтлөх ёстой бичиг баритыг үндэсний бичгээр хослуулан ажлын хэсэгт чиглэл өгч компьютер дээр ажиллах талаар сургалтыг өгч ажиллаж байна.

**2. Хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн ажил**

Хүүхдийн оройн таралт болон өглөө хүлээн авах үед эцэг эх хүүхэддээ хандаж буй харилцаа хандлагыг тогтмол ажиглан насанд хүрсэн хүнээр хүүхдийг байнга авах талаас нь шаардага тавиж байна.

“Мөнгөн өвөл”-экс курс аялал бэлтгэл бүлгийн багш хүүхдүүдтэй хамтран зохион байгуулалаа. Үүнд нийт дунд -13 бэлтгэл бүлгийн -20хүүхэд хамрагдан хөгжилтэй тэмцээн уралдаан зохион байгуулав. Бүлгийн бүх хүүхдүүдэд халуун аарц өглөө.

**3. Ажлын байран дээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал:**

Компьютерийн анхан шатны хэрэглээний програамм дээр сургалт зохион байгуулан бэлтгэл ажил хангагдаж багш ажилчдад сургалтыг өгч мэдлэг чадварыг нь нэмэгдүүлэн ажиллаж байна.

Монгол бичиг хосолсон бичиг болгож байгууллагын хүнсний агуулах болон бүлгүүдийг хаягжуулсан.

Санхүүгийн анхан шатны баримтыг холбогдох заавар журмын дагуу бүрдүүлэн санхүүгийн сахилга баттай ажиллаж байна. https.//www.esis.edu.mn/teacher хаягаар нэвтрэн хоолны цэсийг 7-хоног бүрийн 1-дэх өдөр шивж оруулан баталгаажуулж байна.

ХАБЭА ажилтны хийх ажлын 13 заалт бүхий төлөвлөгөөг гарган байгууллагын 2021 оны архивын дутуу баримтыг үдэж архивлан дуусгаж, 2022он баримтуудыг архивлан хаяглан хавтасласан.

## СӨБ-ИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Цэцэрлэгийн хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжих, хүүхэд хамгаалал, эрүүл ахуй халдвар хамгааллыг сайжруулах, эцэг эхтэй уялдаатай, бүтээн байгуулалттайгаар ажилласан.

**Нэг. Сургалт үйл ажиллагаа**

- Сургалтын чанарыг сайжруулах зорилгоор мини кабинетаар хичээллэж эхэлсэн бөгөөд хүүхдүүдэд шинэлэг хүлээлттэй, сонирхолтой үйл ажиллагаа болж байна. Сургалтад ашиглах ашиглах хэрэглэгдэхүүн, тараах материалыг хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Математикийн үйл ажиллагааны тараах материал хэрэглэгдэхүүн энгийн бодлого зурагт үзүүлэн хугацаа, орон зай,уламжлалт хэмжээ зурагт үзүүлэн, эсгийгээр гурвалжин 160ш, дөрвөлжин дүрс 126,дугуй дүрс 100ш, тоог нүдлэх, бичих 1-10 хүртэл цифртэй тараах материал 31ш-ийг хийсэн. Ахуйн осолын зурагт үзүүлэн 20ш, бидний ёс заншил үзүүлэн ширээний ном гарын авлага бэлтгэж үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна
- Бүлгийн хүүхдүүдэд хэл ярианы хичээлээр дамжуулан цагаан сарын баярын холбогдолтой шүлэг, мэндчилгээний үгийг цээжлүүлэн байгууллагын нээлттэй группэд байршуулсан. Хандалт -88
- Бүлгүүдийн ирцийн тухай бүр нь esis ирц оруулан ажиллаж байна.
- Хувилбарт сургалтын хүүхдүүдэд “ӨНӨӨДРИЙН МЭДЛЭГ-МАРГААШИЙН ИРЭЭДҮЙ” уриан дор ном тоглоомын багц, насны онцлогт тохируулан “Жишиг даалгавар”-ыг боловсруулан 23 хүүхдэд хүргэсэн. Мөн “Хурган төсөл”-ийн даалгаврын аргачлалыг хүргэж, хийсэн дасгал дээр нь дүгнэлт өгөн ажиллаж байна.





- Сар шинийн баярыг тохиолдуулан 3-5 насны хөвгүүдийн дунд уламжлал болгон явагддаг "Энэ хэний бөх вэ?" Барилдааныг зохион байгууллаа. Барилдаанд 3 бүлгийн 35 хүүхэд өрсөлдөж, үзүүр түрүү бөхөө шалгаруулсан.






- Энэ сараас эхлэн сургалт үйл ажиллагаанаас гадуур 11 төрлийн дугуйлан хичээллэж эхэлсэн.

 

- Бүлгийн 4 багшид “Зургаан настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх даалгаврын танилцуулга” сургалтыг зохион явуулж, бэлтгэл бүлгийн хүүхдүүдээс түвшин тогтоох үнэлгээг түүврийн аргаар авч, анализ хийж ажиллаж байна.
- Багш нарын арга зүй, ур чадвар, бие биенээсээ суралцах чадварыг нэмэгдүүлэх үүднээс “САЙН ХИЧЭЭЛ-САЙН ТУРШЛАГА” ур чадварын уралдааныг зохион явуулж, хэлэлцүүлэг хийж ажиллсан. Мөн туслах багш нарын дунд хөгжөөн баясах цагийн үйл ажиллагаагаар “Сайн туршлага” ур чадварын уралдааныг явуулж, алдаа оноогоо дэнсэлж дүгнэсэн.

 

- Багш ажилчид, дунд, ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд “Цэгээр наадъя-Шилдэг бүтээл” уралдааны эхний шалгаруулалтыг явуулсан. Нийт багш ажилчдын 11 бүтээл, хүүхдүүдийн 52 бүтээлээр үзэсгэлэн гаргасан.





- Хүүхдийн суралцах чадварыг нэмэгдүүлж, үгийн баялгийг нэмэгдүүлэх зорилгоор “Бяцхан шинжлэх ухаанч” аяныг зохион байгуулсан бөгөөд энэ үйл ажиллагаагаар хүүхдүүд “Бяцхан багш” болж хичээл заасан. “Бяцхан багш” үйл ажиллагаанд 3 бүлгийн 5 хүүхэд багш болж ажилласан.

 

**Хоёр. Мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байдал**

- Бага насны хүүхэдтэй малчин эцэг эхийг чадавхижуулах төслийн баг буюу МУБИС-СӨБС-ийн Аргазүйн тэнхимийн эрхлэгч доктор Б.Жавзандулам, Боловсролын ерөнхий газарт судлаач Л.Цог-Эрдэнэ, Хүүхдийн номын зохиолч Б.Энхжаргал нар манай цэцэрлэгийн хувилбарт сургалтын 20 эцэг эх, хүүхдүүдэд сургалт ярилцлага, судалгаа, ном уншихын ач тусыг таниулж хамтран ажиллалаа. Энэ үйл ажиллагааны хүрээнд малчин эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хэрхэн хамтран ажиллах, Малчин эцэг эхчүүд гэрийн нөхцөлд хүүхэдтэйгээ ажиллахад зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн багц, Чанар болон тоон мэдээлэлд суурилсан судалгааны өгүүлэл ба цаашид хүүхдээ хөгжүүлэх, тоглох тоглоом зэргийг боловсруулж ажилласан. Энэ өдөр цэцэрлэгийн хувилбарт сургалтанд хамрагдаж байгаа хүүхдүүдийг цэцэрлэгтэй танилцуулж, дуу дуулж, тоглоом тоглох зэрэг сонирхолтой олон арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Энэхүү төсөл нь Говь-

Алтай аймгийн Баян-Уул сум болон Сүхбаатар аймгийн Наран сумын Хүүхдийн цэцэрлэгт хэрэгжиж байгаагаараа онцлоготой.

  

- 2023.01.18,19 өдрүүдэд эрхлэгч Ж.Хүрэлчимэг, багш Г.Эрдэнэцэнгэл нар "Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт эрүүл мэндийн боловсролыг тусган хэрэгжүүлэх нь" сэдэвт сургалтад хамрагдаж, багш ажилчдад мэдээ мэдээллийг хүргэсэн.

 

- Сургуулийн өмнөх боловсролын багш, удирдах ажилтанд зориулсан "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ ба багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих" цахим сургалтад эрхлэгч, 5 багш нарын хамт хамрагдаж, БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХЭРЭГЦЭЭНД ҮНДЭСЛЭН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ ажилласан.

 

- Багш ажилчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх зорилгоор хаалттай групп нээж, "Үндэсний бичгээрээ хичээнгүй бичицгээе" хуулан бичиг бичих ажилд 9 албан хаагч оролцож, цахим хаягт байршуулсан.
- Компьютерийн анхан шатны хэрэглээний программ дээр сургалт зохион байгуулах бэлтгэл ажил хангагдаж сургалтад хамрагдах 5 багш ажилчдаас түвшин тогтоох сорил авч, компьютер дээр суралцаж байна.
- Жижүүр багш, жижүүр, үйлчлэгч, тогоочийн тэмдэглэл, албан хаагчдад монгол бичгээр нэрийн хуудас, Туслах багш нарын хөтөлбөл зохих баримт бичгийг хос бичгээр үйлдсэн.



- Бага насны хүүхдийн хөгжлийг хангахуйц сургалтын орчныг шинэчлэж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэхээр зорилгоор зохион явуулсан " Мини кабинет-сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх" уралдаанд бүлгийн 4 багш, 4 туслах багш нар оролцож, нийт 35 нэр төрлийн хэрэглэгдэхүүнийг гарын доорх материалаар хийсэн.
- Ном уншиж, номын тэмдэглэл хөтлөх "Судар эгшиглэн-2023" төсөлд оролцох эрхээ байгууллагын 10 хүн авсан.

- Хүүхдийг ахуйн хүрээнд санаатай болон санамсаргүй байдлаар  бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлж, багш ажилчид “Осол аюулгүй байцгаая”  цахим контент 3-ыг  бэлдэж, байгууллагын болон ангийн группэ хаягт байршуулсан. Хандалт-89




- Багш ажилчдын монгол бичгийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд “Нэг минут-Нэг мэдлэг” сэдвийн хүрээнд уншлага хийхэд байгууллагын 10 албан хаагч хамрагдсан.




- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан багш ажилчдын дунд ““Бид найрагчийн нутгийнхан” шүлгийн тэмцээнийг зохион байгуулахад 13 хүн оролцож, шилдгүүдээ тодруулсан.




- Аймгийн “Улаан загалманй хороо”-оос зохион явуулсан “Карьераа хэрхэн төлөвлөх вэ?” цахим сургалтад 6 хүн хамрагдсан.



- Боловсролын ерөнхий газраас 1,5,10 дах жилдээ ажиллаж байгаа  удирдах ажилтан, багш нар цахим болон танхимаар сургалцаж байна.
- Сумын ЗДТГ-ын архив албан хэрэг хөтлөлтийн эрхлэгч О.Тунгалаг “Архив, албан хэргийн хөтлөлт, данс бүртгэл үйлдэх” талаар сургалтыг 2 удаа  явуулж, төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийж ажиллах чиглэл өгсөн.




- Төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын сургалтын

байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээний суурь мэдээллийн сан бүрдүүлэх цахим сургалтад эрхлэгч, ЗАН-ийн ахлагч сууж, 4 сард зохион байгуулагдах багшийн гүйцэтгэлийн үнэлгээг хийх арга аргачлалыг авч ажилласан.

- Боловсрлын ерөнхий газраас зохион байгуулж байгаа “Хүүхдийн хөгжлийн үнэлгээний аргазүй” сургалтад 5 багш цахимаар хамрагдаж, мэргэжил аргазүйгээ дээшлүүлэн ажиллаж байна.




- ЗАН-ийн ахлагч, ХАБЭА хариуцан багш ажилчдад “ЦЭНЭГ-НЭГ ӨДӨР” сургалтыг зохион байгуулж, сургалтын чанарыг сайжруулах, хүүхэдтэй харилцах харилцаа хандлага болон хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийг танилцуулж сорил авч ажилласан.

**Гурав. Эцэг эхтэй хамтран ажиллах**

✓ Хүүхдийн насны онцлогийн талаар зөвлөмж боловсруулан багш нарт мэдээлэл өгч, хувилбарт сургалтын 20 эцэг эхэд хүргэсэн.




✓ Эцэг эхэд сургалт үйл ажиллагаа сурталчлах, хүүхдийн оролцоо идэвхийг таниулах үүднээс “Урилгат хичээл” –ийг зохион байгуулахад 10 эцэг эх хамрагдсан бөгөөд 4 багш өөрийн хариуцсан суралцахуйн чиглэл бүрээр хичээл заасан.




✓ Сургуулийн захиргаатай хамтран хүүхдийн уран уншлагын “Уран жиргээ-2023” шүлгийн уралдаанд 3 бүлгийн 15 хүүхэд оролцсон бөгөөд эхний 3 байрыг шалгаруулж, аймагт болсон Уран жиргээ-2023 шүлгийн уралдаанд дунд бүлгийн суралцагч оролцож, үзэгчдийн нэрэмжит шагналыг хүртсэн.

✓ Туслах багш нар эцэг эхчүүдтэй харьцах “Ярилцъя булан”-г тохижуулж, хүүхдийн хөгжил, төлөвшилийн талаар ярилцах боломж бүрдсэн.

**Дөрөв. Халдвар хамгаалалт, халдваргүйжүүлэлт**

- Хүүхдийн хоол хүнс хадгалах склад агуулахыг цэвэрлэн хөргөгч хөлдөөгч хүнсний тавиурыг содын уусмалтай усаар цэвэрлэн ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийдэг.
- Бүлгүүд 7 хоног бүр 0,015% уусмалтай усаар их цэвэрлэгээ хийж хана, тоглоомын тавиур,цонхны тавцанг арчиж хивсээ угааж цэвэрлэдэг.

- Өглөө бүр бүлгийнхээ хүүхдүүдийг хүлээн авч гарыг нь угааж, өдөр бүр амыг зайлж шүдийг нь угаалган хэвшиж байна.
- Анги танхим өрөө тасалгааны агааржуулалтыг 2 цаг тутамд сэлгэх өрөөний агаарын хэмийг 18-20 хэмийн дулаантай тэмдэглэл хөтөлдөг.
- Цэцэрлэг эхлэхийн өмнө,тарсны дараа чийгтэй цэвэрлэгээг 2-3 удаа хийж хэвшсэн.



- Хүүхдийн тоглоомыг зааврын дагуу өдөр бүр угааж халдваргүйжүүлэн ажилладаг.
- Ангийн кварцын гэрлийг15-20 минут орой болгон асааж халдваргүйжүүлж хэвшсэн.
- 7-н хоногийн 5 дахь өдөр бүр бүлгүүд гудсыг салхинд гаргаж халдваргүйжүүлсэн .
- Бүлгийнхээ ор хөнжлийн даавуу нүүр гарын алчуур,унтлаганы хувцасыг угааж индүүдэн ажилладаг.

**Тав. Бусад ажил**

- ЭМТ-ийн “Эрүүл жиндээ” аяны хүрээнд байгууллагын 14 албан хаагч биеийн жингийн индексээ тодорхойлсон.



- Цэцэрлэгийн эмчтэй хамтран 4 бүлгийн 75 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зөвлөгөө заавар авч ажилласан.



- Хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлж буй түүхий эд бүтээгдэхүүнийг гэрээт ААН байгууллагаас татан авалт хийхдээ хугацааг харж хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг буцаан олголт хийж хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
- ДХШ-ыг багш, туслах багш, ажилчид гэсэн 3 чиглэлээр үзүүлэлт гаргаж, зөрчлийг арилган ажиллаж байна.
- Жижүүр гал тогоо болон бүлгүүдийн хог хаягдлыг төвлөрсөн цэгт өдөр бүр шатааж, устгал хийдэг.
- ” Хүүхэд болон иргэд хөдөлмөрчдийг зорчих” аюлгүй байдлыг хангаж өглөө оройн авто хөдөлгөөнийг зохицуулан ажиллаж байна.
- Соёлын төвийн “Биет Бус Өв” түүхийн музеитай ахлах, бэлтгэл бүлгийн 42 суралцагч танилцсан.




- ЭМТ-ийн ёсзүйн баг цэцэрлэгийн ёсзүйн бүлгэмийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцсон.



- Байгууллагын багш ажилчдын дунд Дартсны тэмцээн зохион байгуулж авхаалж самбаагаараа өндөр оноо авсан 2 хүнийг шагнаж урамшуулсан.




- Соёлын төвөөс зохион байгуулсан Сүхбаатар жанжны үйл хэргийг сурталчилсан “ПОСТЕР”-ын уралдаанд 5 хүн амжилттай оролцсон.
- Төрийн албан хаагчийн анкетийг шинэчилэн 15 албан хаагч бөглөж өгсөн.
- Сүхбаатар аймгийн Засаг даргын зүгээс сумдад 65 инчийн ухаалаг дэлгэц өгсөнийг хүлээн авсан.
- https://www.esis.edu.mn/teacher хаягаар нэвтрэн орж хоолны цэсийг 7 хоног бүрийг 1 дэх өдөр шивж оруулан баталгаажуулж байна.
- Байгууллагын багш ажилчдад эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан, карт шинэчилэн нээж хөрөнгийг бүртгэлжүүлсэн.
- Сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг хүргэсэн.

## **СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 1 дүгээр улиралд:

- Ирсэн бичиг – 26
- Явсан бичиг - 6
    - Хариутай бичиг – 14
    - Хугацаандаа явсан бичиг – 13
    - Хугацаа болоогүй бичиг – 1

- Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. 01-р сарын 01-ээс дуу хөгжмийн багш Д.Эрдэнэцэцэг СУИС-ийн эчнээ ангидаа суралцахаар явсанаар дарга, бүртгэл мэдээллийн санч, үйлчлэгч гэсэн албан хаагчид 01-р сард ажиллаа. Аймгийн Соёл, урлагийн газарт ахмад ажилчид болон ардын авъяастануудын 5 хүний шагналын материалыг хүргүүлсэн.

1.2. Байгууллагын статистик мэдээг 01-р сарын 16-ны өдөр эцсийн байдлаар Соёл, урлагийн газрын мэргэжилтэн А.Нармандах-д хүргүүлсэн.

1.3. 01-р сарын 20-ний өдөр сумдын Соёлын төвийн удирдах ажилтануудад мэдээлэл өгөх цахим хуралд даргын үүрэг гүйцэтгэгч Л.Чинбат оролцлоо.

1.4. 02-р сарын 01-ээс Соёлын төвийн дарга Б.Оюунзул хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусаж ажилдаа орсон. Соёлын төвийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Л.Чинбатыг мөн өдрөөс номын санч, архив, бичиг хэргийн ажилтанаар томиллоо.

1.5. 02-р сарын 11,12-ны өдөр Соёл, урлагийн салбарын удирдах ажилтаны нэгдсэн зөвлөгөөнд Соёлын төвийн дарга Б.Оюунзул оролцож, аймгийн Соёл, урлагийн газрын даргатай хамтран ажиллах гэрээгээ баталгаажууллаа.

1.6. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ажилчид хийж, байгууллагын даргаар батлуулаад байна. 03-р сарын 27-нд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргаар батлуулахад бэлэн болсон.

1.7. Улирлын статистик мэдээг номын санч хугацаанд чвуулсан.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Байгууллагын 2022 оны санхүүгийн тайланг аймгийн Аудитын газарт хүргүүлсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны А/72 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Орон Нутгийн Өмчийн газраас ирүүлсэн бичгийн дагуу 01-р сарын 25-ны дотор явуулсан.

2.1. 1-р улирлын төсвийн орлого 19,841,400 төгрөг, өөрийн орлого 1,250,000 төгрөг, зарлага 19,841,400 төгрөг байна.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1. 2023 оны 02-р сарын 01-ний өдрөөс Л.Чинбатыг номын санчаар томилсон.

3.2. 2023 оны 03-р сард Мартын 8-г угтан “Ээждээ захидал бичээрэй” уламжлалт уралдаанаа зарлан шалгарсан оролцогчдын шагналыг баярын өдөр нь олгосон.

3.3. СӨБ болон ЕБС-ийн сурагчдын дунд “Уран жиргээ” уралдааныг хамтран зохион байгууллаа. Шалгарсан сурагчид аймгийн хэмжээний тэмцээнд оролцох эрх авлаа.

3.4. “Судар эгшиглэн” төсөлд оролцох оролцогчдыг бүртгэж, унших номын жагсаалтыг гарган, оролцогчидтой хамтран ажиллахаар боллоо.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1. “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин туулай жилийн сар шинийн баярт зориулан “Цагаан сар” тэмцээнийг албан байгууллага, аж ахуй нэгж, багуудын дунд зохион байгууллаа. Уг тэмцээний зорилго нь монголын цагаан сарын баярын уламжлалт ёс заншил, зан үйлийг үр хойчдоо уламжлан үлдээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчилан таниулах, өв соёлын мэдлэгийг дээшлүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангахад оршиж байсан бөгөөд тэмцээнд оролцсон байгууллагуудаас Эрүүл мэндийн төвийн баг тэргүүн байр эзэллээ.

4.2. “Үзэсгэлэн болгогч” хэмээх харагчин туулай жилийн сар шинийн баярт зориулан шагайн харвааны тэмцээнийг Наран, Дарьганга, Онгон сумын харваачдын дунд зохион байгууллаа. Тэмцээнд 5 багийн 30 гаруй харваачид цэц мэргэнээ сорьсоноос Онгон сумын харваачид тэргүүн байр, Наран, Дарьганга сумын харваачид удаах байруудыг эзэллээ.

4.3. 3-р сарын 1-5 өдрүүдэд “Музей үзэх өдөр” арга хэмжээг зохион байгуулсан ба энэ үеэр Орон нутаг судлах танхимын үзмэрийг 120 үзэгч үзэж сонирхлоо. Үүнээс хүүхэд 108, том хүн 12 хамрагдлаа.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
5.1. Хөгжмийн болон бүжгийн дугуйлан хичээллэж байгаа ба одоогоор бүжгийн дугуйланд 60 хүүхэд, хөгжмийн дугуйланд 25 хүүхэд хамрагдаж байна.

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ:

6.1. Ардын хувьсгалыг үндэслэгч, их жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 02-р сарын 02-с 08-ний өдрүүдэд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийг монгол бичгээр цэвэр сайхан бичих уралдааныг 6-9-р ангийн сурагчдын дунд зохион байгуулахад 47 сурагчийн бүтээл, “Их жанжин Д,Сүхбаатарын хөрөг зураг” гар зургийн уралдааныг 2-5-р ангийн сурагчдын дунд зохиосон ба 50 сурагч, Их жанжин Д.Сүхбаатарын намтар, үйл хэргийг сурталчилсан “Шилдэг постер” уралдааныг төрийн албан хаагчид, иргэдийн дунд зохион байгуулахад 15 оролцогчийн 27 бүтээл тус тус ирсэнийг 02-р сарын 10-ны өдөр шалгаруулж, шагналыг гардууллаа.

6.2. Гэгээн хайрын баярын өдрийг угтан иргэдийн дунд “Хайр хамгийн гоё” гэрэл зураг, мэндчилгээний уралдааныг зохион байгуулахад 7 иргэн оролцсон. Хайрын мэнчилгээг нь 2-р сарын 14-ний өдөр “Үдшийн цэнгүүн” дээр хайртад нь гардуулж өглөө.

6.3. Мартын 8-ны баярыг тохиолдуулан “Цэцэгсийг сонсъё” охидын арга хэмжээ, “Ээждээ захидал бичээрэй” кахидлын уралдаан, “Сэтгэлийн илгээмж” бэлэг хүргэлтийн үйлчилгээ, “Бидний өв соёл” 5-9 ангийн сурагчдын дунд тэмцээн, “Ээжтэйгээ хамтдаа” хөгжөөнт тэмцээн, “Аз жаргалтай эмэгтэйчүүд” баярын арга хэмжээ, “Орчлонгийн сайхан хүүхнүүд” баярын хөтөлбөрт үдшийн цэнгүүн,

“Ээжтэйгээ бүжиглэе” тик ток уралдаан зэрэг арга хэмжээг Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

6.4. 03-р сарын 18-ны өдөр Цэргийн баярт зориулсан “Хөзөрийн бооцоот тэмцээн”, “Баярын жавхаа” хөтөлбөрт үдшийн цэнгүүн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

6.5. “Маск” продакшны жүжигчин МУСТА Дэлгэрсайханы хошин шогийн тоглолт, МУСТА В.Баттулга, Б.Дуулим нарын “Аав нь охиндоо” аялан тоглолт, МУСТА Б.Отгончимэгийн “Цоглог байгаарай” тоглолтуудыг хүлээн авлаа.

ДОЛОО: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

7.1. Байгууллагын гадна гэрэлтүүлгийг засаж сэлбэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

7.2. Хилийн цэргийн дугаар салбарын урлагийн үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулахаар дуу хөгжмийн багш Д.Эрдэнэцэцэг 2 өдөр ажиллаа.

7.3. Аймгийн МАН-ын хороо болон сумын МАН-ын хороо хамтран “Төрийн одон медаль гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллаа.

7.4. Хилийн цэргийн дугаар салбарын урлагийн үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулахад хамтран ажиллаж, техник хэрэгсэл, мэощргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Үүний үр дүнд тус салбар нь Тэргүүн байр эзэллээ.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

### Үндсэн ажилын хүрээнд

- Нийт үзлэг-454
- Урьдчилан сэргийлэх-62
- Амбулаторт-310
- Идэвхитэй хяналт-28
- Дуудлагаар гэрийн-37
- Гэрийн эргэлт-17

Артерийн гипертензин эрт илрүүлэг-64
Чихрийн шижин эрт илрүүлэг-64
Жирэмсний хяналтанд байгаа-19

- Шинээр хамрагдсан-5

Хөхний үзлэг-55
Эсийн шинжилгээ-7
Эмчилсэн эмэгтэйчүүд-1
Эмнэлэгт хэвтсэн-18
Холын дуудлага-39
Төвийн дуудлага-119

- Дусал тариа- 725
- Судас тариа-1258
- Булчин тариа-176
- Арьсан доорх тариа-35

- Уян зүү-39
- Боолт-139

**Сэргээн засах:**

- Хэсэгчилсэн зөөлөн бариа-4
- Утлага-9
- Бумба-4

**Лаборатори:**

- Шээсний шинжилгээ-41
- В,С вирусын шинжилгээ-4
- ДОХ,Тэмбүү шинжилгээ-2
- Сахар-32
- Covid-15
- Альбумин-2
- Билирубин-7
- Үе мөч-6
- Алат асат-8
- Амилаза-14
- Креатинан-4

**Ариутгал**

- Нийт үзлэг багаж-66
- Хөвөн бөмбөлөг-88
- Амбу-34
- Дэлгэш-2
- Эмэгтэйчүүдийн багаж-18
- Эмэгтэйчүүдийн толь-16

## Сургалт сурталчилгаа

**Иргэд рүү чиглэсэн**

1. Зөв хооллолт давсны хэрэглээгээр 16 хүнд сургалт орсон.




2. 5 эхэд хүүхдийн хоолны сургалт орсон.



3. 2023.1 сарын15-2.15ны хугацаанд Осол гэмтлээс урьдчилан сэргийлж “Хүүхэд аюулгүй орчин” сэдэвт аян зохион байгуулагдсан. Энэхүү аяны хүрээнд:








- 2 төрлийн зөвлөмж боловсруулсан гаргаж нийт -96 иргэнд хүргэсэн.





Цахимаар “хүүхдийн зам тээврийн осол гэмтэл, халтиргаа гулгаанаас сэргийлэх, хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх зэрэг 69 мэдээллийг НАРАН ЭМТ пэйж хуудсаар хүргэж, хандалтын тоо 200 гаруй лайк дарсан иргэн 164 байна.







ЕБС-ийн СӨХЗ-ийн гишүүд болон охидын бадмаар бүлгийн гишүүд энэхүү аянд нэгдэж хүүхдийн осол гэтлээс сэргийлэх зөвлөмж, хүхдийн эрхээр бичлэг хийж НАРАН ЭМТ, Хүүхдийн зөвлөл гишүүнээри пэйж хуудсаар дамжуулан эцэг эхчүүдэд хүргэсэн хандалт-150 гаруй.







"Нархан цэцэрлэг"-ийн бэлтгэл бүлгийн багш нартай хамтран эцэг эх, асран хамгаалагч нарыг "Хүүхэд аюулгүй орчин" аянд хамтран ажиллахыг уриалж ажилласан.



Бага насны хүүхэдтэй айл өрхөөр явж эрсдэл учруулж болох хүчин зүйлсийг засаж янзалсан. / 3 өрхийн олон залгуур гэрлийн унтраалгыг зассан./





Дуудлагаар өгсөн нярай болон хүүхдүүдийг хөлийг нь дааруулахгүй байхын тулд нэхийгээр дулаан уут хийж дуудлаганы машинд байрлуулсан.



4. 2023.01.27с эхлэн ЭМТ-өөр үйлчлүүлэгч болон өдрийн эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд Кордиорын сургалтыг зохион байгуулж нийт-64 иргэнд 6 төрлөөр сургалтуудыг орсон.





5. ЭНЭ_ЖИЛДЭЭ_ЭРҮҮЛ_ЖИНДЭЭ аяны нээлтийн үйл ажиллагааг 2023 оны 03.13нд соёлын төвд зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд 45 иргэн оролцсон байна.

Нээлтийн явцад :
1.Нээлтийн үйл ажиллагаа
2.БЖИндекс тодорхойлох

3.Эмчийн үзлэг
4.”Зөв зохистой хоололт”
5.”Таргалалт”
6.Дасгал хөдөлгөөн
7.Зураг авалт чиглэлээр арга хэмжээг зохион байгууллаа.




**Эмч ажилчидад руу чиглэсэн**

1. Бага эмч М.Урангоо 17 эмч ажилчидад “Хорт хавдраас сэргийлье” сургалтыг зохион байгуулсан.




2. Эх баригч Ө.Мөнгөнтогос “БЗХӨ”-с сэргийлье 15 ажилчидад дотоодын сургалтыг зохион байгуулж сургалтын дараах мэдлэг шалгах асуулттай чихэр үйл ажиллагааг зохион байгуулсан.




3. Ахлах сувилагч Г.Уранбилэг “Хэвтрийн өвчтөний байрлал сэлгэх” сэдвээр 15 ажилчидад сургалт орсон.

## Гадаад сургалт

1.2023 оны 1 сарын 27 нд  Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт Мэс заслын тасгаас зохион байгуулсан “Осол гэмтлийн үед үзүүлэх тусламж” онол, практик хосолсон сургалтанд Их эмч, Бага эмч, сувилагч нар  хамрагдсан.

2.2023 оны 1 сарын 28 Сүхбаатар аймгийн ЭМГазар зохион байгуулагдсан “Эмнэлэгийн мэргэжилтний харилцааны онцлог” 1 багц цагийн сургалт,

3.“Сувилахуйн тусламж үйлчилгээний чадварт суралцах нь” 2 багц цагийн сургалтанд ахлах сувилагчийн хамт хамрагдаж 2023 оны багц цагийн кредит зэрэг сургалтанд сувилагч нар хамрагдсан.



1. 2023 оны 3 сарын 9-11 нд  ЭМГазараас зохион багуулсан* Халдварын сэргийлэлт хяналт-2023* бүсчилсэн сургалт Сүхбаатар сумандаа 6 сумын хамтарсан сургалтанд суусан. Их эмч Э.Саранзул НЭМА С.Зулцэцэг






2.ХАБЭА-н хавсран гүйцэтгэдэг ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг мөрдөх, тэдгээрт нийцүүлэн дотоод дүрэм, журмыг боловсруулан хэрэгжүүлж, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах хуулийн мэдлэг ур чадвар дээшлүүлэх зорилгоор“Сертификат”-тай сургалтанд сүхбаатар аймагт А.Буд хамрагдсан.



## Шинэлэг ажил

1. Байгууллагын 18 ажилчидад өвлийн дулаан хувцсаар хангалт хийсэн.




2. Галч нарын нийгмийн баталгааг хангах зорилгоор амрах, алжаал тайлах байр гаргаж тохижуулж өгсөн.



3. Онгон сумын хэвлийн эхоны Б.Батбилэг эмчтэй хамтран Наран сумынхаа отроор яваа 17өрхийн 24 иргэдэд

- Эмчийн үзлэг
- Хэвлийн эхо
- Эрүүл мэндийн зөвлөмж -35ш мөн дархлаа дэмжих багц 10 ширхэгийг эмийн сангаас иргэдэд хүргүүлсэн.







2. ЭМТ нь лабораторийн шинжилгээнүүдийг нэмэгдүүлэх зорилгоор Биохимийн аппарадыг  УБ хотод тохиргоо хийлгэж шинжилгээ хийхэд бэлэн болгосон.иргэдэд шинжилгээг цаг алдалгүй хийж байна.





т
асат, билирубин ,альбумин, шф, ггт, шээсний хүчил, амилаза,креатинин,мочевин,сахарийн шинжилгээнүүд нэмэгдсэн. Мөн үе мөч, цусны бүлэг резус фастор үзэж эхэлсэн.




4.Шээсний анализаторийг шинээр авч LEU,NIT,URO,PRO,PH,BLD,SG,VC,KET,BIL,GLU,CAL,MAL,CRE гэсэн 14 үзүүлэлтийг шинээр үзэж байна.




## Бусад

1. Эмч ажилчид 2023 онд хийгдэх үйл ажиллгааны төлөвлөгөөг даргаар батлуулсан.
2. 2022 оны шилдэг эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарыг шалгуур хуудсаар дүгнэн шалгаруулсан.




3. ЭМЯ-аас ахмадад зориулсан дархлаажуулалтын 150ш багц ирж 1,2,3-р багийн ахмадуудад амбулаториор болон гэрийн эргэлтээр багцыг олгосон.





4. Төрсөн эх нярайг 7хоног бүрийн 4дахь өдөр гэрийн эргэлт хийж зөвлөгөө зөвлөмж өгч байна.



5. Байгууллагын 2022 оны  жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 16 төрлөөр гаргаж 2023.01.06-11г хүртэл АЭМГ-т биеэр очин тайланг өгсөн.



6. Ажилчдад болон үйлчлүүлэгчидэд  аарц, чацарганаар дархлааг дэмжин өгч байна.







7. Халдвар хамгааллыг чанд мөрдөн байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол, хийж байна







ТАЙЛАН НЭГТГЭСЭН: О.ТУНГАЛАГ